


OZONFILT® болон Bono Zon® озоны тоног төхөөрөмжүүд



1. Озоныг ус боловсруулахад ашиглах нь


Озон нь ус боловсруулахад ашиглагддаг хамгийн хүчтэй исэлдүүлэгч бөгөөд дараахь олон зориулалтаар хэрэглэгддэг:

Өндөр үр дүнтэй ариутгал

- Бактер, вирус
- Мөөгөнцөр болон шимэгчүүд

Усан дахь органик бус хортой зохисгүй бодисуудыг исэлдүүлнэ

- Төмөр, манган
- Хүнцэл
- Нитрит, сульфид




Усан дахь органик гаралтай зохисгүй нэгдлүүдийг исэлдүүлнэ

- Хурц үнэр амттай нэгдлүүд
- Усны өнгөнд нөлөөлдөг ялзмаг бусад нэгдлүүд
- Нүүрс устөрөгчийн органик нэгдлүүд
- Trihalomethane-ууд, хлорамин болон бусад хлорт нэгдлүүд

Микрофлокуляцийн үйлчлэл:

- Усанд ууссан бодисууд болон коллоидууд озонгоор исэлдүүлсний дараа үл уусах мөн шүүгдэх чанартай болно.



Озоны үйлдвэрлэл, хэрэглээ нь бусад ижил төстэй исэлдүүлэгч, ариутгагч бодисуудтай харьцуулахад байгаль орчинд маш бага сөрөг нөлөө үзүүлдэгээрээ онцлогтой. Өндөр урвалын идэвхитэй хий болох озоныг зориулагдсан генераторт газар дээр нь хүчилтөрөгчөөс үйлдвэрлэж авсанаар завсрын хадгалалт шаардахгүйгээр шууд усанд уусгах боломжтой. Урвалд орох чанар өндөр тул озон нь хагас задралын үеийн хувьд хэдхэн минутын дотор усан дотор буцаад хүчилтөрөгч болж задардаг. Озоныг үйлдвэрлэж, ашиглах үйл явц нь нарийн дэс дараатай урьдчилсан төлөвлөгөөний дагуу явагдвал үр ашгаа сайн өгдөг.

Манай инженерүүд 1971 оноос хойш тасралтгүй ажиллан, озоныг дараах газруудад ашиглан олон жилийн туршлага хуримтлуулж ирсэн юм.

Ундны усан хангамж

- Усан дахь төмөр, манган, хүнцэлийг исэлдүүлэх
- Усны өнгө үзэмж болон амтыг сайжруулах
- Ариутгал

Хүнсний болон ундааны үйлдвэрлэл

- Эрдэст усны ариутгал
- Ундааны үйлдвэрийн зайлагч машины ариутгал
- Үйлдвэрлэлийн хэрэглээний усны ариутгал

Бассейнууд

- Усан дахь хлорамин, трихалометаныг багасган, бассейнд олонтаа тохиолддог хурц үнэрийг дарах.
- Микрофлокуляцийн үйлчлэлийн үр дүнд маш тунгалаг цэвэр устай болгох.
- Сувиллын зориулалттай бассейнд микробиологийн найдвартай хамгаалагч
- Усны нийт эргэлт болон цэвэр усны хэрэглээг багасгаснаар, нийт хөрөнгө оруулалт, ашиглалтын урсгал зардлыг багасгах.

Аж үйлдвэрлэлийн салбарт

- Хөргөлтийн усны боловсруулалт
- Хөргөлтийн усны legionella бактертай тэмцэх
- Үйлдвэрлэлийн зориулалттай усны ариутгал
- Агаар цэвэршүүлэгчийн үнэртэй бодисыг арилгах

2. Озоны тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны товч танилцуулга

ProMaqua® озоны тоног төхөөрөмжүүд нь цахилгааны нам цэнэглэлийн шалгагдсан зарчмаар ажиллана. Хэдэн мянган вольтын өндөр хүчдэлээр диэлектрикээр тусгаарлагдсан хоёр электродын хооронд хүчилтөрөгчөөс озон гаргаж авдаг. Озоны тоног төхөөрөмжийн төрлөөс хамаарч орчны хуурай болгосон агаар эсвэл коцентрацжуулсан хүчилтөрөгч ашиглана. ProMaqua® озоны тоног төхөөрөмжүүд өндөр ашигтай буюу үйлдвэрийн аюулгүй ажиллагааны хамгийн оновчтой нөхцөлийг хангахаар бүтээгдсэн байдаг. Озон үйлдвэрлэх төхөөрөмжүүдэд тавигдах Германы DIN 19627 стандартын дагуу үйлдвэрлэгдсэн байдаг ба энергийн болон хөргөх усны бага хэрэглээгээрээ онцлог юм.

Дундаж давтамжтай даралтын системс

OZONFILT® OZVa болон OZMa ангиллын төхөөрөмжүүдийн хувьд агаар эсвэл хүчилтөрөгчийг озон гаргагч руу шахан, дундаж давтамжтай өндөр хүчдэлээр үйлчилж озоныг гаргаж авадаг.

Суурилагдсан хувьсах даралтат хатаагч болон оновчтой хэмжээний дулааныг дамжуулах цахилгаан тусгаарлагч-диэлектрикийн хэрэглээ нь төхөөрөмжийг маш бага оврынх болгох нөхцөлийг бүрдүүлдэг.

Үйл ажиллагаа нь даралтанд явагдах тул үйлдвэрлэгдсэн озоныг 2 бар хүртэлх эсрэг даралттай усны системд шууд дамжуулах боломжтой байдаг. Иймээс ихэнхи хэрэглээнд нэмэлт даралтын насос, шахуурга хэрэглэх шаардлагагүй байдаг.

Вакуум систем

Bono Zon® BONA ангиллын төхөөрөмжүүдийн хувьд үйлдвэрлэлийн хий-агаар нь даралтын насос болон шахуургын системийн тусламжтайгаар агаар хатаагч болон озоны генератороор дамжин сорогдоно. Озон үйлдвэрлэл нь өөрөө сүлжээний давтамжин (50Hz) дор явагддаг ба өндөр хүчдэлийн өөрчлөлтөөр хянагддаг. Вакуум систем нь өндөр хэмжээнд аюулгүй ажиллагааг хангадаг.

ProMaqua® нь төрөл бүрийн зориулалттай озоны тоног төхөөрөмжүүдийг санал болгож байна. Доорх хүснэгтэд төхөөрөмжийн загвар тус бүрийн хүчин чадлыг үзүүлэв.

	OZVa 1-4	OZVa 5-7	OZMa 1-3 A	OZMa 1-3 O	BONa
Output [g ozone/h]					
1.000					
500					
200					
100					
50					
20					
10					
5					
2					
Operating gas	Air	Oxygen	Air	Oxygen	Air
Ozone concentration	20 g/Nm ³	100 g/Nm ³	20 g/Nm ³	100 g/Nm ³	20 g/Nm ³

Илүү өндөр хүчин чадалтай системүүдийг захиалгаар нийлүүлэх боломжтой

ProMaqua® озоны тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааг хангахын тулд шаардлагатай бүх төрлийн зөвлөгөө өгнө:

- Газар дээр нь байдлыг үнэлж зөвлөгөө өгөх мэргэжилтний үйлчилгээ.
- Өөрийн лабораторид усны шинжилгээг хийж төхөөрөмжийн тохиромжтой загварыг оновчлоход шаардагдах параметруудийг тодорхойлно.
- Тоног төхөөрөмжийн төлөвлөлт хийнэ.
- Сайн бэлтгэгдсэн мэргэжилтнүүд тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулах мөн засварын үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.